



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/558

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсад шинэ үеийн татварын алба үүсэж хөгжсөний 29 жилийн ойг тохиолдуулан, аймаг, орон нутгийн хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалт, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үйлсэд өөрийн сэтгэл зүрх, эрдэм мэдлэгээ дайчлан үр бүтээлтэй ажиллаж буй хавсралтанд дурдсан нэр бүхий иргэдийг аймгийн Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 90000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 90000 төгрөг / ерэн мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.


3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2020 оны 09
дүгээр сарын 30-ны өдрийн
А/558 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН “ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ”-ӨӨР
ШАГНАГДАХ ХҮМҮҮСИЙН НЭРС

| № | Овог нэр | Эрхэлж буй ажил, албан тушаал | Мөнгөн дүн |
|---|--------------|--|------------|
| 1 | Д.Пүрэвсүрэн | Татварын хэлтсийн улсын байцаагч | 30000 |
| 2 | П.Өнөрбилэг | Татварын хэлтсийн улсын байцаагч | 30000 |
| 3 | Л.Баясгалан | Цэцэрлэгийн нярав, бичиг хэргийн ажилтан | 30000 |

-оОо-